



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 12 сарын 14 өдөр

Дугаар 613

Улаанбаатар хот

Төрийн өмчид эд хөрөнгө бүртгэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон нийт 9 нэрийн 4,498,027,463.00 (дөрвөн тэрбум дөрвөн зуун ерэн найман сая хорин долоон мянга дөрвөн зуун жаран гурван) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг Хил хамгаалах ерөнхий газар, харьяа анги, нэгжийн үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Билгүүн, Хил хамгаалах ерөнхий газрын дарга, хошууч генерал Ц.Сэргэлэнд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө бүртгэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД

0001102

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 12 дүгээр сарын 1-ны өдрийн
613. дугаар тогтоолын хавсралт

**ХИЛ ХАМГААЛАХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

№	Хөрөнгийн нэр	Хэм- жих нэгж	Тоо хэм- жээ	Балансын үнэ (төгрөг)	Тайлбар
1	Цэргийн байр	ш	1	644,429,500.00	Ховд аймгийн Булган сум, Баянмодны заставын барилга
2	Агуулах	ш	1	164,157,078.00	
3	Хоёр машины гараж	ш	1	130,134,736.00	
4	Орон сууц	ш	2	846,087,391.00	
5	Гадна бохирын цооног	м.куб	30	44,546,667.00	
6	Гадна цахилгааны шугам	м	10	45,191,345.00	
7	Гадна хашаа, зам, жагсаалын талбай	м.кв	360	125,453,283.00	
8	Штабын байр	ш	1	1,798,395,489.00	Хилийн 0243 дугаар ангийн барилга, байгууламж (Сэлэнгэ аймаг)
9	Барилгын их засвар	м	30x10x1 0	699,631,974.00	Их ямаатын застав (Хөвсгөл, Цэцэрлэг сум), 0166 дугаар анги(Өмнөговь Гурвантэс сум), 0131 (Өмнөговь Даланзадгад, Хонин уулсын застав (Хөвсгөл, Баянзүрх сум)
	Дүн			4,498,027,463.00	
				(дөрвөн тэрбум дөрвөн зуун ерэн найман сая хорин долоон мянга дөрвөн зуун жаран гурван)	